



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 9873


Ховд

Г Журам батлах тухай Г

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- “Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, хариуцлага, бүтээмжийг сайжруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Журмын хэрэгжилтийг хангаж, “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-нд холбогдох заалтуудыг тусган мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, 17 сумын Засаг даргын Тамгын газрын дарга наарт үүрэг болгосугай.
- Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн дарга (Д.Энхболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 4961

D/Zah-A/873-Bo



Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 27-ны өдрийн  
A/873 дугаар захирамжийн хавсралт

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ МӨРДӨЖ, ХАРИУЦЛАГА, БҮТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. “Байгальд ээлтэй хоггүй аймаг болох”, “Санхүүгийн зөрчилгүй аймаг болох”, “Бүтээмж өндөртэй аймаг болох” зорилтын хүрээнд төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, төрийн албаны стандартыг шаардлагаар бус, санаачлагаараа мөрдөж ажиллах соёл, дэг журмыг хэвшүүлэхэд журмын зорилго оршино.

1.2. Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга), төрийн албаны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Чадварлаг, ёс зүй, хариуцлагатай төрийн алба”-тай болох зорилт тусган хэрэгжүүлж, үр дүнг ил тод тооцдог, хариуцлага, сахилгын механизмыг бүрдүүлэх, ёс зүйн өндөр шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдыг сурган хөгжүүлж, бүтээмж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг шинэ шатанд гаргана.

1.3. Бүх шатны төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээ мөрдөн, сахилга хариуцлагыг сайжруулж, цагийн менежментийг баримталж ажилласнаар шат шатны албан тушаалтан, албан хаагчдын үүрэг хариуцлага дээшилж, ил тод, шуурхай, шударга төрийн албаны тасралтгүй, залгамж чанарыг хадгална.

1.4. Журмыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, 17 сумын Засаг даргын Тамгын газар, төрийн албан хаагчид Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мөрдлөг болгон ажиллана.

### Хоёр. Хурал зөвлөгөөн, уулзалт, нийтийг хамарсан арга хэмжээ.

Төрийн бүх шатны албан хаагчид төрийн албаны манлайлал, ёс зүй, хариуцлага, цагийн менежментийг баримталж, журамт үүргийнхээ хүрээнд доор дурдсан арга хэмжээнүүдэд өөрийн биеэр заавал оролцно.

2.1. Төрийн бүх шатны албан хаагчдын биечлэн оролцох уулзалт, хурал зөвлөгөөн:

2.1.1. Төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны уулзалт;

2.1.2. Харьяалагдах багийн иргэдийн Нийтийн болон багийн хурал;

2.1.3. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан хариуцсан салбарын хурал зөвлөгөөн, уулзалт, сургалт семинар;

2.2. Төрийн бүх шатны албан хаагчдын заавал биечлэн оролцох олон нийтийн арга хэмжээ:

2.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, 2010 оны “Үндэсний мод тарих зарлах тухай” 63 дугаар зарлигийн дагуу жил бүрийн 5, 10 дугаар сарын “Үндэсний мод тарих өдөр”-өөр мод тарих;

2.2.2. Аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж буй бүх нийтийн цэвэрлэгээ;

2.2.3. Бусад

2.3. Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд оролцох:

2.3.1. Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг Жаргалант сум хариуцан сард 1 удаа зохион байгуулна.

Үүнд:

2.3.1.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нар мэдээлэл хийх зайлшгүй шаардлагатай тохиолдолд оролцоно.

2.3.1.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, тасгийн дарга нар;

2.3.1.1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, төсөвт байгууллагуудын удирдлагууд тус тус биечлэн оролцоно.

#### **Гурав. Цахим засаглал.**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж, цахим технологид тулгуурласан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний хэлбэрт бүрэн шилжих нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар цахим үйлчилгээний нэгдсэн <https://e-mongolia.mn/> системийг 2020 оны 10 дугаар сараас эхлэн нэвтрүүлж, иргэд [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn) веб портал болон “E-Mongolia” гар утасны аппликацийн ашиглан аль нэг төрийн байгууллагыг зорьж очилгүйгээр, өөрт хэрэгтэй төрийн үйлчилгээг гэрээсээ эсвэл ажил дээрээсээ ямар ч цаг үед авах боломжийг “E-Mongolia” олгож байна.

Манай аймгийн хувьд төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, мэдээллийн урсгалыг сайжруулах, хариуцлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор 17 сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем” нэвтрүүлж, төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлснээр 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 3200 орчим иргэнд 54 төрлийн үйлчилгээг нэг дорос олгох үйлчилгээ үзүүлсэн байна.

Цаашид цахим засаглалыг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үүнд:

3.1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, 17 сумын Засаг даргын Тамгын газар “Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авах систем” нэвтрүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах;

3.2. Сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулах ажлыг эрчимжүүлэх;

3.3. Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем буюу оператор (<https://operator.e-mongolia.mn/auth/login>)-ын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

3.4. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан “Үйлчилгээний нэгдсэн төв”, “Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем буюу оператор”-ын системийн үйлчилгээний давуу талын талаар иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй сурталчлах;

**Дөрөв. Төрийн албан хаагчдын нийтлэг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага.**

4.2. “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж, албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа этгээд байдлаар, албан бус хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэж, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих;

4.3. Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;

Тав. Хариуцлага.

5.1. Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сахилга хариуцлагыг сайжруулах, цагийн мөнежментийг баримталж ажиллах чиглэлээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, 17 сумын Засаг

даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал” гэсэн заалт оруулж, хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх нэг гол үзүүлэлт болгоно.

5.1.1. Уулзалт, хурал зөвлөгөөний ирцийн бүртгэлийг дараах байдлаар хийнэ.

5.1.1.1. Төрийн албан хаагчдад харьяа багийн иргэдийн Нийтийн Хурал болон багийн хуралтай өдөр нь (3-4 цаг) байгууллагаас албан ёсоор чөлөө олгоно.

5.1.1.2. Албан ёсны хүндэтгэн үзэх шалтгааныг (томилолтоор ажиллах, өөр аймаг, хотод сургалт, семинар, зөвлөгөөнд оролцох, өвчний акт, чөлөө, ар гэрийн гачигдал) хүлээн авна.

5.1.1.3. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцоогүй тохиолдол хариуцлага хүлээлгэнэ.

-оОо-